



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2015 оны 02 сарын 26 өдөр

Дугаар А/73

Мөрөн

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29.2, 29.1.6 "а", Засгийн газрын 2009 оны 73 дугаар тогтоол, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 53, 2014 оны 83 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улс, орон нутгийн төсөв хандив тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний гэрээний хэрэгжилтэнд хяналт тавих, гэрээний хэрэгжилтийн мэдээллийг shilendans.gov.mn, pmmis.mof.gov.mn, e-procurement.mn, meps.gov.mn, khovsgol.gov.mn, khovsgoltender.mn мэдээллийн сайтуудад нийтлэх, уг мэдээллийг тайлагнах, иргэд олон нийтэд сурталчилах, цахим тендер зохион байгуулах зэрэг ажиллагаанд шаардлагатай холбоо, интернетийн зардлын төсвийг хавсралтаар баталсугай.

2. Гэрээний хэрэгжилтийн мэдээллийг мэдээллийн сайтуудад нийтлэх, холбогдох байгууллагуудад тайлагнах, олон нийтэд сурталчилах, цахим тендер зохион байгуулах ажиллагаанд шаардлагатай зардал 7,853,000/Долоон сая найман зуун тавин гурван мянган/ төгрөгийг захиалагчийн хяналтын зардлаас санхүүжүүлэхийг Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга /Г.Сувд/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын дэргэдэх Худалдан авах ажиллагааны албаны дарга /Б.Болд/-д үүрэг болгосугай.

ДАРГА



А.ЭРДЭНЭБААТАР

ЦАХИМ ТЕНДЕР ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖИЛЛАГААНД ШААРДЛАГАТАЙ  
ИНТЕРНЕТИЙН ХОЛБОЛТ, АШИГЛАЛТЫН ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	ЗАРДЛЫН ТӨРӨЛ	САНАЛ БОЛГОЖ БУЙ ҮНЭ	ТАЙЛБАР	НӨАТ	НИЙТ ГАРАХ ҮНЭ
1	Суурилуулалтын зардал	400 000			400 000
2	Тоног төхөөрөмжийн үнэ	400 000	Сүлжээний толгой, 500 метр кабель, конвертер г.м	40 000	440 000
3	Төлбөр /3 мв/	5 760 000	Сар бүр 561 000	576 000	6 336 000
4	Шөрмөс /шилэн кабель/	360 000		36 000	396 000
5	Энгийн Switch	90 000			90 000
6	Wireless router	70 000			70 000
7	Rack 6 unit N172-0106	110 000		11 000	121 000
	<b>Нийт дүн</b>				<b>7 853 000</b>